

МӨНГӨНИЙ ТОЙМ

2010 оны 4 дүгээр сар

1. ҮНЭ

Үндэсний статистикийн хорооны мэдээгээр 2010 оны 4 дүгээр сард хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ улсын хэмжээнд өмнөх сартай харьцуулахад 2.1 хувь, оны эхнээс 9.7 хувь, өмнөх оны мөн үеэс 8.3 хувь, Улаанбаатар хотын хэмжээнд өмнөх сараас 2.5 хувь, оны эхнээс 11.4 хувь, өмнөх оны мөн үеэс 8.4 хувиар тус тус өссөн байна. Хэрэглээний үнийн индексийг ашиглан тооцсон *суурь инфляци* өмнөх сартай харьцуулахад 0.2 хувиар буурч, харин оны эхнээс 2.0 хувь, өмнөх оны мөн үеэс 5.2 хувиар өссөн байна.

Хүснэгт 1

Хэрэглээний барааны үнийн индекс

	Хувийн жин	<u>2010-IV</u> 2009-IV	<u>2010-IV</u> 2009-XII	<u>2010-IV</u> 2010-III
Хүнсний бараа, ундаа, ус	41.1	109.9	123.7	105.3
Согтууруулах ундаа, тамхи	2.3	111.2	101.5	100.2
Хувцас, бөс бараа, гутал	12.4	109.7	103.4	99.8
Орон сууц, ус, цахилгаан, түлш	13.4	102.8	99.7	100.1
Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа	4.3	103.2	101.2	101.1
Эм, тариа, эмнэлгийн үйлчилгээ	1.6	113.0	100.7	100.4
Тээвэр	8.7	104.0	101.0	100.1
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	4.1	116.4	116.9	100.0
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	3.3	101.3	100.9	100.2
Боловсролын үйлчилгээ	4.2	109.0	100.0	100.0
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлч.	1.7	118.4	109.3	100.2
Бусад бараа үйлчилгээ	3.0	110.5	101.8	100.5
Ерөнхий индекс	100.0	108.4	111.4	102.5


Эх үүсвэр: Статистикийн сарын бюллетень, Үндэсний статистикийн хороо (Улаанбаатар хотын индекс)

Улаанбаатар хотын хэрэглээний үнийн индекс 2010 оны 4 дүгээр сард 2.5 хувиар өссөн нь Хүнсний бараа, ундаа, ус бүлгийн дүн 5.3 хувиар нэмэгдсэнээс шалтгаалсан. Бусад бүлгүүдийн дүн харьцангуй тогтвортой буюу 0.1-1.1 хувиар тус тус өсчээ.

Өрхийн хэрэглээнд өндөр хувийн жин эзэлдэг махны үнэ өнгөрсөн оны 12 дугаар сараас хойш өндөр хурдацтай өсч байна. Тайлант сард хонины махны үнэ 15.5 хувь, үхрийн махных 15.1 хувь, адууны махных 9.6 хувиар тус тус өссөн бөгөөд махны үнийн өсөлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад хонины махных 2.0 нэгж хувь, үхрийн махных 12.6 нэгж хувь, адууны махных 7.1 нэгж хувиар тус тус илүү хурдтай өсөв. Хүнсний барааны бүлэгт ордог гурилын үнэ өмнөх саруудтай адил буурч байгаа бөгөөд мөн тайлант сард 5.1-8.3 хувиар буурсан байна.

Зураг 1

Инфляци



2. МӨНГӨНИЙ НИЙЛҮҮЛЭЛТ

Мөнгөний нийлүүлэлт¹ өмнөх оны мөн үеийнхээс 35.1 хувь буюу 821.1 тэрбум төгрөг, өмнөх сарынхаас 6.3 хувь буюу 188.5 тэрбум төгрөгөөр өсч 3163.0 тэрбум төгрөгт хүрэв. Мөнгөний нийлүүлэлтийн жилийн өсөлт өнгөрсөн оны мөн үеийнхээс 40.1 нэгж хувь, өмнөх сарынхаас 8.6 нэгж хувиар өсч 2008 оны мөн үеийн түвшинд хүрсэн байна. Тайлант сард төгрөгийн хадгаламж буурч, харин мөнгөний нийлүүлэлтэд ордог бусад үзүүлэлтүүд өсчээ. Ялангуяа гадаад валютын харилцах мэдэгдэхүйц нэмэгдсэн байна. Тухайлбал, гадаад валютын харилцах тайлант сард 22.0 хувь буюу 78.6 тэрбум төгрөгөөр өсөв. Хадгаламж, зээлийн хоршоо дахь хадгаламж нь 2010 оны 4 дүгээр сарын байдлаар банкуудын хадгаламжийн 1.5 хувийг эзэлж байв. Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө өмнөх оны мөн үеэс 25.1 хувь буюу 89.4 тэрбум төгрөг, өмнөх сарынхаас 15.7 хувь буюу 60.5 тэрбум төгрөгөөр өсч 445.0 тэрбум төгрөгт хүрчээ.

2.1 Мөнгөний нийлүүлэлтийн бүрэлдэхүүн

Мөнгөний нийлүүлэлтийн бүтцийг эх үүсвэр талаас нь авч үзвэл, бараг мөнгө 76.2 хувь (үүнд төгрөгийн хадгаламж 43.1 хувь, гадаад валютын хадгаламж 19.3 хувь, гадаад валютын харилцах 13.8 хувь), бага мөнгө буюу M1 мөнгө 23.8 хувь (үүнд банкнаас гадуурх мөнгө 10.7 хувь, төгрөгийн харилцах 13.1 хувь)-ийг тус тус бүрдүүлсэн байна.

¹ M2-мөнгөний нийлүүлэлт нь бараг мөнгө, M1 мөнгөний нийлбэр.

Хүснэгт 2

Мөнгөний үзүүлэлтийн жилийн өсөлт (жил бүрийн 4-р сарын байдлаар, хувиар)

	М2 мөнгөнд эзлэх хувь*	2007	2008	2009	2010
М1 мөнгө	23.8%	55.42	28.24	-11.27	45.65
Банкнаас гадуурх мөнгө	10.7%	44.38	8.65	5.19	18.07
Төгрөгийн харилцах	13.1%	71.66	52.48	-25.77	80.10
Бараг мөнгө	76.2%	49.05	31.82	-3.14	32.06
М2 мөнгө	100.0%	50.54	30.95	-5.06	35.06

*2010 оны 4 сарын байдлаар

Бараг мөнгө

Бараг мөнгө өмнөх оны мөн үеэс 32.1 хувь буюу 584.7 тэрбум төгрөг, өмнөх сараас 5.6 хувь буюу 127.2 тэрбум төгрөгөөр өсч 2408.7 тэрбум төгрөгт хүрэв. Бараг мөнгөний жилийн өсөлт нь өмнөх оны мөн үеэс 35.2 нэгж хувь, өмнөх сараас 8.1 нэгж хувиар нэмэгдсэн байна.

Нийт хадгаламж өнгөрсөн оны мөн үеэс 32.5 хувь буюу 483.9 тэрбум төгрөг, өмнөх сараас 2.5 хувь буюу 48.6 тэрбум төгрөгөөр өсч 1973.5 тэрбум төгрөгт хүрчээ. Тайлант сард иргэдийн төгрөгийн хадгаламж 1.3 хувь буюу 16.2 тэрбум төгрөгөөр буурч, харин аж ахуйн нэгж, байгууллагуудын төгрөгийн хадгаламж 5.8 хувь буюу 5.4 тэрбум төгрөг, гадаад валютын хадгаламж 10.8 хувь буюу 59.4 тэрбум төгрөгөөр тус тус өсөв. Гадаад валютын хадгаламжийн хувьд өнгөрсөн оны 12 дугаар сараас хойш буурч байсан бол тайлант сард өссөн үзүүлэлттэй гарчээ. Гадаад валютын харилцах өмнөх оны мөн үетэй харьцуулахад 30.1 хувь буюу 100.1 тэрбум төгрөг, өмнөх сараас 22.0 хувь буюу 78.6 тэрбум төгрөгөөр нэмэгджээ. Гадаад валютын харилцах, хадгаламжийн өсөлт нь бараг мөнгөний өсөлтөд нөлөөлсөн байна.

Нийт хадгаламжийн 69.1 хувь нь төгрөгийнх, 30.9 хувь нь валютын хадгаламж байсан бөгөөд төгрөгийн хадгаламжийн нийт хадгаламжид эзлэх хувь 2009 оны мөн үетэй харьцуулахад 2.1 нэгж хувиар өсч, харин 2008 оны мөн үеэс 2.6 нэгж хувиар буурчээ.


Бага мөнгө

Бага мөнгө (М1) өмнөх оны мөн үеэс 45.6 хувь буюу 236.4 тэрбум төгрөг, өмнөх сараас 8.8 хувь буюу 61.3 тэрбум төгрөгөөр өсч 754.3 тэрбум төгрөгт хүрсэн байна. Бага мөнгөний жилийн өсөлтийн хурд 2009 оны мөн үеийнхээс 56.9 нэгж хувь, өмнөх сарынхаас 10.1 нэгж хувиар нэмэгджээ. Төгрөгийн харилцах өмнөх оны мөн үеэс 80.1 хувь буюу 184.4 тэрбум төгрөг, өмнөх сараас 4.0 хувь буюу 16.0 тэрбум төгрөгөөр өсч 414.6 тэрбум төгрөгт хүрсэн байна. Банкнаас гадуурх мөнгө гүйлгээнд байгаа бэлэн мөнгөний 76.3 хувийг эзэлж байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 4.6 нэгж хувиар бага байв. Мөн банкнаас

гадуурх мөнгө M2-ийн харьцаа 10.7 хувь болсон нь өнгөрсөн оны мөн үеэс 1.5 нэгж хувиар бага байна.

Зураг 2

M1, M2, Бараг мөнгөний жилийн өөрчлөлт, хувиар



2.2 Нөөц мөнгө


Нөөц мөнгө өмнөх оны мөн үеэс 39.2 хувь буюу 209.9 тэрбум төгрөг, өмнөх сараас 10.0 хувь буюу 67.9 тэрбум төгрөгөөр өсч 746.0 тэрбум төгрөгт хүрсэн байна. Тайлант сард банкнаас гадуурх мөнгө 15.4 хувь буюу 45.3 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн нь нөөц мөнгөний өсөлтөд голлон нөлөөлсөн байна. Банкнаас гадуурх мөнгөний нөөц мөнгөнд эзлэх хувь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 8.1 нэгж хувиар буурч 45.5 хувь болсон бол Төв банкин дахь харилцах, хадгаламжийнх нь 6.9 нэгж хувь, банкуудын кассынх 1.2 нэгж хувиар тус тус өсч 40.6 хувь болон 13.9 хувьтай тэнцэж байв.

2.3 Гадаад, дотоод цэвэр актив

Гадаад цэвэр актив өмнөх оны мөн үеийнхээс 2 дахин буюу 918.6 тэрбум төгрөг, өмнөх сарынхаас 14.5 хувь буюу 209.2 тэрбум төгрөгөөр өсч 1651.5 тэрбум төгрөг, дотоод цэвэр актив өмнөх оны мөн үеийнхээс 6.1 хувь буюу 97.5 тэрбум төгрөг, өмнөх сарынхаас 1.4 хувь буюу 20.7 тэрбум төгрөгөөр буурч 1511.5 тэрбум төгрөг болжээ. Мөнгөний нийлүүлэлтийг байршуулалт талаас нь авч үзвэл нийт мөнгөний 52.2 хувь нь гадаад цэвэр активт, 47.8 хувь нь дотоод цэвэр активт байршиж байна. Гадаад цэвэр активын M2 мөнгөнд эзлэх хувь өмнөх сараас 3.7 нэгж хувь, өмнөх оны мөн үеийнхээс 20.9 нэгж хувиар нэмэгдсэн байна.

Зураг 3

Гадаад, дотоод цэвэр актив, тэрбум төгрөгөөр



Гадаад валютын цэвэр албан нөөц

Гадаад валютын цэвэр албан нөөц өмнөх оны мөн үеэс 2.3 дахин хувь буюу 673.8 сая ам.доллар, өмнөх сараас 9.4 хувь буюу 104.4 сая ам.доллараар өсч 1211.8 сая ам.долларт хүрсэн байна. Энэ нь импортын 25.2 долоо хоног буюу 6.3 сарын төлбөртэй дүйцэхүйц байна.

Зээл

Хадгаламжийн байгууллагуудаас² олгосон зээл тайлант сарын эцэст 2764.9 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеийнхээс 7.2 хувь буюу 184.6 тэрбум төгрөгөөр өсч, харин өмнөх сарынхаас 0.1 хувь буюу 3.7 тэрбум төгрөгөөр буурчээ. Хадгаламж, зээлийн хоршоодоос олгосон зээл банкуудын зээлийн 1.2 хувьтай тэнцэж байна. Хадгаламжийн байгууллагуудаас хувийн хэвшилд олгосон нийт зээл өнгөрсөн оны мөн үеийнхээс 8.9 хувь буюу 144.1 тэрбум төгрөгөөр өсч 1766.0 тэрбум төгрөг, иргэдэд олгосон зээл 4.5 хувь буюу 41.7 тэрбум төгрөгөөр өсч 972.2 тэрбум төгрөг, бусад байгууллагад олгосон зээл 88.6 хувь буюу 4.7 тэрбум төгрөгөөр өсч 10.1 тэрбум төгрөгт тус тус хүрсэн бол улсын байгууллагуудад олгосон зээл өмнөх оны мөн үеийнхээс 26.1 хувь буюу 5.9 тэрбум төгрөгөөр буурч 16.6 тэрбум төгрөг болов. Зээлийн өрийн үлдэгдлийн жилийн өсөлт 2009 оны 12 дугаар сараас хойш нэмэгдсээр байгаа бөгөөд тайлант сард өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.3 нэгж хувиар өсчээ. Энэ нь иргэдэд олгосон зээлийн өрийн үлдэгдлийн жилийн өсөлт өнгөрсөн оны мөн үеийнхээс 14.3 нэгж хувиар өссөнтэй холбоотой. Харин

² Хадгаламжийн байгууллагад банкуудаас гадна мөнгөний нийлүүлэлтийн тооцоонд ордог харилцах, хадгаламж хэлбэрээр бусдаас хөрөнгө татан төвлөрүүлдэг санхүүгийн байгууллага хамрагдана.

хувийн хэвшилд олгосон зээлийн өрийн үлдэгдлийн жилийн өсөлт 2009 оны 4 дүгээр сард 19.5 хувьтай байсан бол тайлант сард өнгөрсөн оны мөн үеийнхээс 10.6 нэгж хувиар саарсан байна.

Хүснэгт 3


Зээлийн өрийн үлдэгдэл (жил бүрийн 4-р сарын байдлаар, тэрбум төгрөг)

	2006	2007	2008	2009	2010
Нийт зээл	981.8	1,477.6	2,436.5	2,580.2	2,764.9
жилийн өөрчлөлт (%)	53.1	50.5	64.9	5.9	7.2
Төгрөгийн зээлийн хүү	27.3	22.3	21.7	19.5	20.5
жилийн өөрчлөлт (%)	-5.4	-5.0	-0.6	-2.3	1.0
Валютын зээлийн хүү	16.2	16.3	13.9	19.9	15.6
жилийн өөрчлөлт (%)	-0.1	0.1	-2.4	6.0	-4.3

Нийт зээлийн үлдэгдлийн 79.9 хувийг хэвийн зээл, 5.0 хувийг хугацаа хэтэрсэн зээл, 15.0 хувийг чанаргүй зээл тус тус эзэлж байна. Чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувийн жин өмнөх сараас 0.6 нэгж хувиар буурсан бол өмнөх оны мөн үеэс 4.4 нэгж хувиар өсчээ.

Зураг 4

Зээлийн өрийн үлдэгдэл (жил бүрийн 4-р сарын байдлаар)



Нийт зээлийг өмчлөгчөөр нь авч үзвэл 63.9 хувь нь хувийн хэвшил, 35.2 хувь нь иргэд, 0.6 хувь нь улсын байгууллага, 0.4 хувь нь бусад байгууллагад олгосон зээл байна.

Зээлийн хүү

Төв банкны үнэт цаасны жигнэсэн дундаж хүү өнгөрсөн оны мөн үеэс 6.1 нэгж хувиар буурч, харин өмнөх сарынхаас өөрчлөгдөөгүй жилийн 10.03 хувьтай байв.

Банкуудын төгрөгийн болон гадаад валютын зээлийн жигнэсэн дундаж хүү³ өмнөх сараас 0.4 нэгж хувь, 0.6 нэгж хувиар тус тус өсч жилийн 20.5 хувь болон 15.6 хувьд тус тус хүрчээ. Тайлант сард банкуудаас төгрөгөөр олгосон зээлийн жигнэсэн дундаж хүү 6.0-24.7 хувь, валютаар олгосон зээлийн жигнэсэн дундаж хүү 11.6-21.6 хувийн хооронд хэлбэлзэж байв.

3. МӨНГӨНИЙ ЗАХ ЗЭЭЛ

2010 оны 4 дүгээр сард банк хоорондын захын арилжаагаар нийт 19.5 тэрбум төгрөгийн гүйлгээ хийгдсэн бөгөөд үүний 5.1 хувь нь репо, 14.6 хувь нь банк хооронд олгосон зээл, 80.3 хувь нь банк хоорондын хадгаламж байв. Эдгээр арилжааны жигнэсэн дундаж хүү жилийн 10.23 хувь байлаа. Банк хоорондын захын жигнэсэн дундаж хүү өмнөх оны мөн үеэс 5.5 нэгж хувиар буурсан бол өмнөх сараас 3.0 нэгж хувиар өсчээ. Тайлант сард банк хоорондын хадгаламжийн хүү 1.3 нэгж хувиар өсч 10.43 хувь болсон нь банк хоорондын жигнэсэн дундаж хүүгийн өсөлтөд нөлөөлсөн байна.

2010 оны 3 дугаар сарын 24-ний өдрөөс 2010 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн хугацаанд банкууд дунджаар төгрөгийн заавал байлгах нөөцөд 99.1 тэрбум төгрөг, валютын заавал байлгах нөөцөд 56.0 тэрбум төгрөг байлгах шаардлагыг хангаж ажиллав. Банкууд төгрөгийн заавал байлгах нөөцөд 102.1 тэрбум төгрөг, валютын нөөцөд 62.2 тэрбум төгрөг тус тус төвлөрүүлсэн байна.

4. ВАЛЮТЫН ХАНШ

Төгрөгийн ам. доллартай харьцах ханш 2010 оны 4 дүгээр сарын эцэст 1372.46 төгрөг болж, өмнөх сараас 5 төгрөгөөр суларч, харин өмнөх оны мөн үеэс 51 төгрөгөөр чангарсан байна. 2010 оны 4 дүгээр сард төгрөгийн ам. доллартай харьцах дундаж ханш 1382.64 төгрөг болсон нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 48 төгрөг, өмнөх сарынхаас 30 төгрөгөөр чангарчээ.

МОНГОЛБАНК

³ Зарласан хүү